



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/20/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах Аудитор Д.Цэрэнханд Утас: 99147999 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	5
3.1 Ерөнхий зүйл.....	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	6
3.4 Материаллаг байдал.....	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	7
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.17 № 01

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР

07930010

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>970,751,159.00</u>	<u>752,777,562.00</u>
33	АВЛАГА	970,751,159.00	752,777,562.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	500,000.00	314,600.00
335	Бусад авлага	970,251,159.00	752,462,962.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	970,251,159.00	752,462,962.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>970,751,159.00</u>	<u>752,777,562.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>90312663.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	90312663.00	0.00
413	Өглөг	90312663.00	0.00
4136	Бусад өглөг	90312663.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	90312663.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>880,438,496.00</u>	<u>752,777,562.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	880,438,496.00	752,777,562.00
512	Хуримтлагдсан үр дүн	880,438,496.00	752,777,562.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,139,949,256.79	951,338,496.00
51220	Тайлант үеийн үр дүн	(259,510,760.79)	(198,560,934.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>970,751,159.00</u>	<u>752,777,562.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	555,222,100.00	648,887,363.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,800,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,222,100.00	641,087,363.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	246,927,100.00	641,087,363.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,895,000.00	11,602,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,032,100.00	629,484,863.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	814,732,860.79	847,448,297.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	814,732,860.79	847,448,297.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,242,932.08	14,698,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,174,932.08	7,034,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,174,932.08	5,534,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,068,000.00	7,664,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,068,000.00	7,664,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	812,489,928.71	832,749,947.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	341,939,327.79	244,496,820.00

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	341,939,327.79	244,496,820.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,179,167.92	32,064,930.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,179,167.92	32,064,930.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	456,371,433.00	556,188,197.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	456,371,433.00	556,188,197.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(259,510,760.79)	(198,560,934.00)


2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	880,438,496.00	880,438,496.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	880,438,496.00	880,438,496.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		0.00
C07	Тайлант үеийн үр дүн		0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	880,438,496.00	880,438,496.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	880,438,496.00	880,438,496.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	70,900,000.00	70,900,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	951,338,496.00	951,338,496.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	-198,560,934.00	-198,560,934.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	752,777,562.00	752,777,562.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,012,093,533.00	1,205,075,560.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	456,871,433.00	563,988,197.00
120	Нийтлэг татварын бус орлого	456,871,433.00	563,988,197.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	456,871,433.00	563,988,197.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	456,871,433.00	556,188,197.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,222,100.00	641,087,363.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	246,927,100.00	641,087,363.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,895,000.00	11,602,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,032,100.00	629,484,863.00

ГАА-2022/20/НА-СТА-ОНТС



Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,012,093,533.00	1,205,075,560.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,093,533.00	1,205,075,560.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,242,932.08	14,698,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,174,932.08	7,034,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,174,932.08	5,534,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,068,000.00	7,664,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,068,000.00	7,664,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,009,850,600.92	1,190,377,210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	538,800,000.00	601,809,483.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	538,800,000.00	601,809,483.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,179,167.92	32,379,530.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,179,167.92	32,379,530.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	456,871,433.00	556,188,197.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	456,871,433.00	556,188,197.00


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	657,327,363.00	616,507,833.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,327,363.00	616,507,833.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,150,700.00	14,698,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,048,200.00	7,034,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,548,200.00	5,534,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,102,500.00	7,664,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,102,500.00	7,664,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	641,176,663.00	601,809,483.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	641,176,663.00	601,809,483.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	641,176,663.00	601,809,483.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	665,567,363.00	1,205,075,560.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	653,964,863.00	629,484,863.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	653,964,863.00	629,484,863.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,602,500.00	575,590,697.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,602,500.00	11,602,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	641,087,363.00

ГАА-2022/20/НА-СТА-ОНТС



21	УРСГАЛ ЗАРДАЛ	641,087,363.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,698,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,034,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,534,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,664,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,664,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	626,389,013.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	601,809,483.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	601,809,483.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,579,530.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	24,579,530.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	641,087,363.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	641,087,363.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,602,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	629,484,863.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтны тоог нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар халамж хүртэгч иргэдийн хүрээг багасгаж хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ гэсэн зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцүүлэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогын хэрэгжилтийг ханган, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломж бүрдүүлэх зэрэг бодлого чиглэл баримтлан ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 555.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 648.8 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход төгрөгөөс 2 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.3 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15 хувиар буюу 127.7 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэлгүй бөгөөд тайлант онд 18.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулан, эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 970.7 сая төгрөг бөгөөд тайлант онд авлага 338.7 сая төгрөгийн зээлийн болон татаас санхүүжилтийн авлага нэмэгдэн, 556.6 сая төгрөгийн авлага барагдан, 752.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 90.3 сая төгрөг нь 2020 онд олгогдоогүй байсан төсөл хөтөлбөрүүдийн үлдэгдэл бөгөөд тайлант онд барагдуулж өр төлбөргүй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 752.7 сая төгрөг болж 127.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 16.8 хувиар буюу 93.6 сая төгрөгөөр өссөн нь зээлийн эргэн төлөлт өссөнтэй холбоотой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 752.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 705.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 39.8 сая төгрөгөөр бууруулж, 665.5 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 665.5 сая төгрөгийн төсөв баталснаас 653.9 сая төгрөгийг ХЭДС-гаас, 11.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ХЭДСангаас 629.5 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 11.6 сая төгрөг нийт 641.0 сая төгрөгийн орлого орж, 24.5 сая төгрөгийг ХЭДС-д буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 616.5 сая төгрөг буюу 93 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар ХЭДС-аас 629.4 сая төгрөг, дэлхийн банкны санхүүжилтээр 11.6 сая төгрөг нийт 641.0 сая төгрөгийн орлого орсноос төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулалд 601.8 сая төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 24.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 7.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, НӨАТ-ын тухай хуулийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 1,602.9 сая төгрөгийн 104 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 1,438.9 сая төгрөгийн 102 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Шилэн дансанд 90.3 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 73.7 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад мэдээлсэн.

Горим сорил хэрэгжүүлсэний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт

Горим сорил хэрэгжүүлсэний үр дүнд тайлант онд худалдан авалтын и баримттай холбоотой зөрчил илрээгүй тул НӨАТ-ын тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9.0 сая төгрөгийн зөрчилд 3 заалт албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн боловч зөрчил давтан гарсаар байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар төсвийн хэмнэлт, төсөл хөтөлбөрийн бодит үр дүн хэрэгжилтийн талаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Шилэн дансанд 90.3 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 73.7 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад мэдээлсэн

4.2 Төлбөрийн акт

Зээлийн гэрээ дууссан зээлдэгч нартай холбоотой 2.4 сая төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", "зээлдэгч нартай байгуулсан

холбогдох гэрээ"-ний заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтооллоо.

4.3 Албан шаардлага

Зээлийн гэрээ дуусаагүй зээлдэгч нартай холбоотой 13.6 сая төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", "зээлдэгч нартай байгуулсан холбогдох гэрээ"-ний заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.4-т" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх , 1.5-д "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл




Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХЭДС	3	15.9			1	2.4	2	13.6		
	Дүн	3	15.9			1	2.4	2	13.6		



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн СТА Аудитын код: ГАА-2022/20/-НА
Байгууллагын нэр: ХЗДС

№	Нөлөөлж буй АГАДУТ	Товч утга	Мөнгөн дүн	Материалл аг эсэх	Үр өгөхөөр тооцож эсэх	Шалгуур		Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын санал тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт				
1	Ажил гүйцэтгэлийн анги	Зээлийн гэрээ дууссан эзэлдэгч нэртэй холбоотой 2,412.0 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна.	2,412.00	2,412.00	2,412.00	УСНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захиралтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Зээлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө"	Төлбөрийн акт	Шаардлагагүй	Шаардлагагүй	Төлбөрийн акт
2	Ажил гүйцэтгэлийн анги	Зээлийн гэрээ дууссаагүй эзэлдэгч нэртэй холбоотой 15,402.6 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна.	13,565.00	13,565.00	13,565.00	УСНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.5	Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захиралтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", зээлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө"	Албан шаардлага	Шаардлагагүй	Албан шаардлага	
3	Ажил гүйцэтгэлийн анги	Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 ваас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй				УСНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан хаагчдын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алмаал тайлах, фитнессийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх	Албан шаардлага	Шаардлагагүй	Албан шаардлага	
			15,877.00	15,977.00	15,977.00	16,294.66					

Ахлах Аудитор:  Д.Цэрэнханд, 2022.02.15
Анхны шатанд хянасан:  Д.Эрдэмчимэг, 2022.02.15
Хоёр дахь шатанд хянасан:  Х.Урушинбаяр, 2022.02.15
Дарга, Тэргүүлэх аудитор: 

Танилцаж зөвшөөрсөн:
ХХҮГ-ын Дарга
Нягтлан бодогч
Д.Баттайван, 2022.02.15
Л.Удавал, 2022.02.15

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Код:	
Баримт бичгийн төрөл	Санхүүгийн тайлангийн аудлит
Аудитын нэр	ХЭДС
Хугацаа заасан эсэх	Тийм <input type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй
Ажил гүйцэтгэсэн:	Ахлах аудитор Аудитын менежер

Д.Цэрэнханд
Д.Эрдэнэчимэг



2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хүснэгт

Огноо	Хүлээн авсан	Буцааж өгсөн	Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
			Хангалттай	Засвар, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Засвар хийгээд дахин үзүүлэх				
2022.02.11	2022.02.11	+				Дараагийн шатанд хянуулах		Ж.Бүжинханд	Хяналтад өгсөн
2022.02.11	2022.02.12	+				Дарга нь түр орлон уу, дарга уу гэдгийг харах, Акт, албан шаардлагын хяналтын хуудсыг бөглөх. ХЭДС гийн хувьд гүйцэтгэлийн аудитаар үзэх асуудал байвал дараа үзэх асуудал хэсэгт тусгаарай		Д.Эрдэнэчимэг	Дарга байна. Бүртгэл хяналтын хуудсыг хөтөлсөн байна
2022.02.11	2022.02.12	+				Өмнөх аудитын зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогчид арга хэмжээ авч байгаа. Сангийн хувьд 2021 оны эзэлийг хугацаанд нь төлөөгүй ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулсан, байгууллагагүй эсэхээс хамаарч харилцлага тооцох албан шаардлага тооцох эсэхийг шийдвэрлэх саналтай байна.		Д.Эрдэнэчимэг	Цар тахалтай холбоотойгоор ХНХЯ-аас эзэлийг хойшлуулах тушаал гарсан байгаа. Үүнтэй холбоотойгоор эзэлийн төлөлтүүд хойшлогдсон, хугацаа хэтрэлттэй эзэлийн хувьд Шүүхэд өгч шийдвэрлүүлсэн байсан.
2022.02.14	2022.02.14	+				Сангаас олгож байгаа зээл нь тэвчиж болох зардалд орж тооцогдох үү, энэ нь зардал биш эргэж төлөгдөх зээл юм. Эргэн харах		Х.Түвшинбаяр	Эргэн харж заслаа, сангийн хувьд үйл ажиллагаа явуулахад зайлшгүй гарах шаардлагатай зардлууд байна.
2022.02.14	2022.02.14	+				УАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу дараагийн аудитаар авч үзэх асуудлыг бичих		Х.Түвшинбаяр	Тайланд засаж оруулаа.
2022.02.14	2022.02.14	+				Тайланд шараар будсан хэсгийг засах		Х.Түвшинбаяр	Шараар будсан хэсгийг заслаа
2022.02.14	2022.02.14	+				Шийдвэрийг Сайханжаргалаар хянуулах		Х.Түвшинбаяр	Хянуулахаар 2022 оны 02-дугаар сарын 14-нд хүргүүлээ.

Аудитын тайланг баталгаажуулахыг зөвшөөрсөн

Дарга, Тэргүүлэх аудитор

/ Х.Түвшинбаяр/

оны ... сарын



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Код:	
Баримт бичгийн төрөл	Санхүүгийн тайлангийн аудлит
Аудитын нэр	Улсын бүртгэлийн хэлтэс
Хугацаа заасан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй
Ажил гүйцэтгэсэн:	Ахлах аудитор Аудитын менежер

[Signature] Д.Цэрэнханд
[Signature] Д.Эрдэнэчимэг

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хүснэгт

Огноо		Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
Хүлээн авсан	Буцааж өгсөн	Хангалттай	Засвар, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Засвар хийгээд дахин үзүүлэх				
2022.02.09	2022.02.09		+		Шинээр томилогдсон албан тушаалтны төрийн албаны шалгалт өгсөн мэдээлэлтэй тулгах		Ж.Бүжинханд	Шинээр томилогдсон албан тушаалтан Алтанцаг нь 2009 онд төрийн албаны шалгалт өгч тэнцэн, газрын албанд ажиллаж байсан бөгөөд шилжин ажилласан. Баасанжаргал 2020 онд өгч тэнцсэн хүний нөөцөд бүртгэлтэй байна.п
2022.02.12	2022.02.13		+		Хөндлөнгийн тулгалтын мэдээллийг бүрэн бөглөх		Д.Эрдэнэчимэг	Хөндлөнгийн мэдээллийг бөглөсөн
2022.02.14	2022.02.14	+			Тайланд шараар будсан хэсгийг засварлах		Х.Түвшинбаяр	Тайланд шараар будсан хэсгийг заслаа
2022.02.14	2022.02.14	+			Тайлангийн 3.9-д шилэн дансыг бүрэн хөтөлсөн гэх боловч нийцэхгүй байна гэсэн өгүүлбэр байна харах		Х.Түвшинбаяр	3.9-д нийцсэн гэж өөрчилж оруулсан
2022.02.14	2022.02.14	+			ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу ҮХ худалдан авсан болон дараагийн аудитаар авч үзэх асуудлыг бичих		Х.Түвшинбаяр	Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй гэж өөрчиллөө.
2022.02.14	2022.02.14	+			Шийдвэрийг Сайханжаргалаар хянуулах		Х.Түвшинбаяр	Хянуулахаар хүргүүллээ
2022.02.14	2022.02.14	+			43 тогтоолын 10 хувийн хэмнэлтийн тухайд зөрчлийн утгаа эргэн харах		Х.Түвшинбаяр	Зөрчлийн утгыг заслаа

Аудитын тайланг баталгаажуулахыг зөвшөөрсөн

Дарга, Тэргүүлэх аудитор

/ Х.Түвшинбаяр/

..... оны сарын

8217144139
ДНОА0060 9018301

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн СТА Аудитын код: ГАА-2022/20-НА-СТА-ОН
Байгууллагын нэр: ХЭДС

№	Нөлөөлж буй АГАДУТ	АГАДУТ-н дэд анги	Товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Шалгуур		Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын санал тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт				
1	Ажил гүйцэтгэлийн анги	Авллага	Зөвлөлийн гэрээ дууссан эзэлдэгч нартай холбоотой 2,412.0 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна	2,412.00	2,412.00	2,412.00	УОНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4.2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захиралтай байгуулсан гэрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих", эзэлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дамжлагыг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дамжлагыг эргэн төлнө"				
2	Ажил гүйцэтгэлийн анги	Авллага	Зөвлөлийн гэрээ дуусаагүй эзэлдэгч нартай холбоотой 15,402.6 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна	13,565.00	13,565.00	13,565.00	УОНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4.2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.5	Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захиралтай байгуулсан гэрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих", эзэлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дамжлагыг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дамжлагыг эргэн төлнө"	Албан шаардлага			
3	Ажил гүйцэтгэлийн анги	Зардал	Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж амжилтагүй				УОНББОУС-1, АДБОУС-1250, 1300, МНС-6817-4.2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "ТБОНХ-өөр барив, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан тогторын тавилга, албаны ажлын дүрэм, хувиар, амралт алжаалт тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх	Албан шаардлага			
				15,977.00	15,977.00	15,977.00						

Ахлах Аудитор: *[Signature]*
Анхан шатанд хөндсөн: *[Signature]*
Аудитын мөхөөжөгч: *[Signature]*
Хоёр дахь шатанд хөндсөн: *[Signature]*
Дарга, Тэргүүлэх аудитор: *[Signature]*

Бэлтгэсэн: Д.Цэрэнжанд 2022.02.15
Д.Эрдэнэчимэг 2022.02.15
Х.Түвшинбаяр 2022.02.15

821744139
ТНОА/МНС/СТ/13/01

XXУГ-ын Дарга
Нягтлан бодогч

Танилцаж зөвшөөрсөн:
Д.Баттайван 2022.02.15
Л.Удвал 2022.02.15